

БИД БҮГД ХОГОО ДАХИВАРТ ТУШААВАЛ, БИД БҮГД ХОЖНО

Та баглаа боодлын материал, сонин зэргийг дахиварт тушаах бүрдээ том ажлын эхлэлийг тавьдаг.

ДАХИВАР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
ТАСАЛГААНУУД
БА ДАХИН
БОЛОВСРУУЛАЛТЫН
ТӨВҮҮД

MORE INFORMATION

Хуучин лонхны тагийг автомашины их биеийн шинэ хуудас металл болгон хувиргах боломжтой. Угаалгын нунтгийн хоосон хайрцаг ЖИШЭЭ НЬ, шинэ гутлын хайрцаг болно. Өчигдрийн сонин маргаашийн мэдээ болно. Байгалийн түүхий эдийг дахин ашиглахад, их эрчим хүч хэмнэгдэнэ. Ингэснээр бид амьдарч буй дэлхий ертөнцөө улам таатай сайхан болгоход хувь нэмрээ оруулна.

Хоол хүнсний илүүдлийг био хий ба био бордоо болгож дахин боловсруулдаг бөгөөд үлдсэн хаягдалыг тог ба дулаан болгож хувиргадаг. Цуглуулсан бүх сав баглаа боодол, сониныг дахин боловсруулж шинэ сав баглаа боодол, шинэ бүтээгдэхүүн гаргадаг. Хуванцар сав баглаа боодол нь жишээлбэл сав суулга угаах сойз, цэцгийн сав, гялгар уутны орц материал болно. Шил, цаасан сав баглаа боодол ихэвчлэн өөр сав баглаа боодлын материал болдог. Төмөр савлагаа нь дугуйн хүрээ болдог ба хэрэглэсэн сонингууд гэр ахуйн цаас эсвэл шинэ мэдээний хэвлэлийн эх үүсвэр болж хувирдаг.

Хоол хүнснээс үлдсэн хаягдалыг та амьдарч байгаа газартаа байх тусгай савд хийж, дахиварын төвүүдэд өгч хуримтлуулах шаардлагатай. Хэрвээ та өөрийн оршин суугаа хэсэгт сонин буюу сав баглааг орхиж хаях боломжгүй бол, үүнийгээ та дахин боловсруулах хүнгүй төвд л зөвхөн орхих хэрэгтэй. Тэнд бүх төрлийн савлагаанд зориулсан контейнерууд байдаг: хуванцар, цаас, металл буюу шил ба цаас сонингийн савууд ч байдаг. Зориулалтын саванд багтаж орохгүй том хэмжээний савлагаа ба боодлыг та дахин боловсруулалт эсвэл дахиварын төвүүдэд үлдээж болно.

Та www.sopor.nu гэсэн хаягаар орж хамгийн ойр байрлах дахиварын станцыг олж, хэзээ түүнийг хоосолж, цэвэрлэдгийг шалгаж болно. Үүний зэрэгцээ ангиллын тухай зааварчилгаа, дахин боловсруулалтын тухай кино, эх сурвалжаар нь ангилах зөвлөгөө ба зөвлөмжүүд байдаг.

Хэрвээ танд хаягдал ба дахиварын тухай асуулт гарвал, та өөрийн хотын захиргаатай холбогдоорой. Тэд их хэмжээний хог хаягдал, бордоо, цахим хаягдал болон бусад хог хаягдалын тухай асуултаудад хариу өгөх болно.

НАРИЙН АНГИЛАХ

Аль болох их хог хаягдлыг дахин боловсруулах боломжийг бүрдүүлэхэд бидэнд таны тусламж шаардлагатай.

- Олон янзын хог хаягдлыг хооронд нь бүү холиорой.
- Хоол хүнсний хаягдлыг зориулалтын тусгай саванд хийдэг.
- Үлдэгдэл хогийг маш сайн уяж хаасан уутанд хийнэ.
- Сав баглаа боодлыг бүрэн хоосолж, хуурай болгох ёстой. Хэрэв таны сав баглаа боодлыг нэгээс олон төрлийн материалаар хийсэн бол түүнийг хамгийн их жин дарж байгаа гэж бодсон материал руугаа ангилах ёстой.



- ✓ Ногоо жимсний хаягдал, цайны боодол, кофены хаягдал, өндөгний хальс, амьтны яс ба үүнтэй адил зүйлс. Гал тогооны цаас бага зэргээр бас сайн байдаг.
- ✗ Хуванцар, хамрын тамхи, тамхи, цэцэг ба лаа зэрэг нь хоол хүнсний хог хаягдал биш.




- ✓ Лонх, лааз, сав, гялгар уут, цэнэглэх уутнууд, хуванцар хоолойнууд, шарсан төмсний уутнууд, полистирен. Ямар нэгэн таглаа, бөглөө байвал ав. Өөр өөр төрлийн пластик сав баглаа боодол бүхий уутнуудыг тус тусад нь өөр саванд хийнэ үү. Ингэснээр дахин боловсруулах дараагийн үе шатыг хялбар дөхөм болгоно.
- ✗ Сав баглаа боодлоос өөр пластик бүтээгдэхүүнийг, жишээ нь тавилга, тоглоомыг бөөн эсвэл ахуйн хог хаягдалд ангилж ялгана. Тушаадаг лонх савыг дэлгүүрт тушааж буцаан олголт авах хэрэгтэй.



- ✓ Цагаан тугалган лааз, хоосон шүрших сав, хоолой, лонхны таг, таглаа, хоосон будгийн лааз. Цагаан тугалган лаазны хурц ирмэгтэй тагийг дотогш нь нугал.
- ✗ Будаг, цавууны үлдэгдэл агуулсан лаазыг аюултай хог хаягдалд ангилах ёстой. Сав баглаа боодол биш хаягдал металл, сантехникийн эд анги, хайруулын таваг болон бусад бүтээгдэхүүнийг бөөн буюу ахуйн хог хаягдалд ангилах ёстой. Тушаадаг лаазнуудыг дэлгүүрт тушааж буцаан олголт авах хэрэгтэй.



- ✓ Гоймонгийн хайрцаг, сүү, шүүсний картон сав, цаасан уут, гуталны хайрцаг, ариун цэврийн цаасны гол, картон хайрцаг. Хавтгайлж, голоор нь нугал. Жижиг сав баглаа боодлыг томд нь хийж, зай хэмнэ.
- ✗ Дугтуйг ахуйн хог хаягдал эсвэл шатаах хог хаягдалд ангилах ёстой. Сонин, сурталчилгааны хуудас болон эдгээртэй төстэй материалыг сонинд зориулсан саванд хийх ёстой.



- ✓ Өдөр тутмын болон долоо хоног тутмын сонин, сэтгүүл, каталог, сурталчилгааны хуудас, өдрийн тэмдэглэл, бичих/зурах цаас. Пластик боодол болон сурталчилгааны наалтыг ав.
- ✗ Дугтуй болон нуруутай номыг ахуйн хог хаягдал эсвэл шатаах хог хаягдалд ангилах ёстой. Цаасан уут, картон сав болон эдгээртэй төстэй материалыг цаасан сав баглаа боодлын материалд зориулсан саванд хийх ёстой.



- ✓ Өнгөтэй эсвэл тунгалаг шилэн лонх, сав. Таг, таглаа, үйсэн бөглөөг нь авч, харгалзах материалын төрөлд нь ангил. Өнгөтэй эсвэл тунгалаг шилэн сав баглаа боодлыг зөв саванд ангилж хий.
- ✗ Тушаадаг лонх савыг дэлгүүрт тушааж буцаан олголт авах хэрэгтэй. Сав баглаа боодол биш шаазан, керамик болон бусад бүтээгдэхүүнийг бөөн буюу ахуйн хог хаягдалд ангилах ёстой. Гэрлийн чийдэн, урт гэрлийг ер нь орон нутгийн эрх бүхий байгууллагын ажилтантай дахиврын төв рүү аваачих ёстой.



- ✓ Аяга тавагны алчуур, дугтуй, хамрын тамхи, шүдний сойз ба самаас гарах үс.
- ✗ Дахин боловсруулж болох зүйлсийг явч ердийн хогийн саванд хийж болохгүй! Аюул учруулж болох хаягдал ба цахилгаан төхөөрөмжийн хаягдлуудыг хогийн саванд хийдэггүй; та үүнийг дахин боловсруулах төвд авчирч өгөх шаардлагатай.